



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨААТҮГ 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Азаяа

Утас: 99125777

цахим хаяг: tsazzaya@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.03.20 № 1
танай 2024.05.11 -ны № 85 -Т

**ШИНЭ ХОВД ЖАРГАЛАНТ
ТҮК ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.АЛИМАА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Аймгийн ИТХ-ын 2023 оны 12/03 дугаар тогтоолоор Шугам сүлжээ орон сууц ашиглалтын газар ОНӨААТҮГ-ыг татан буулгасантай холбоотой тухайн үйлдвэрийн газрын 326,375.8 мянган төгрөгийн орлого, зардал, тайлант онд үүссэн 13,700.0 мянган төгрөгийн авлага, 16,703.6 мянган төгрөгийн өр төлбөр, 87.7 мянган төгрөгийн дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, 37,631.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэн тайлан балансд нэгтгэн гаргасан байна.

Аудитын гол асуудал

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн хурлын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлж жил бүр баталж, биелэлтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллана гэж дүрэмдээ заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталаагүй байна.

Гүйцэтгэлээр 1,254.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,254.0 мянган төгрөгийн зардал гарган, 485,584.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 85 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх үүрэг, хариуцлага

Компанийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,039,970.14	146,205,498.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	33,880.14	205,798.61
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	33,880.14	205,798.61
31210	Төгрөг	33,880.14	205,798.61
31213	Арилжааны банк дахь харилцах	33,880.14	205,798.61
33	АВЛАГА	0	13,700,000.00
33500	Бусад авлага	0	13,700,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0	13,700,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,306,090.00	132,299,700.00
35400	Хангамжийн материал	27,306,090.00	132,299,700.00
35420	Аж ахуйн материал	454,000.00	6,323,700.00
35470	Бусад хангамжийн материал	26,852,090.00	125,976,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	387,471,185.68	769,012,055.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	387,471,185.68	769,012,055.61
39200	Биет хөрөнгө	386,452,435.70	768,308,930.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	564,829,900.00	584,829,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-223,440,611.82	-306,126,591.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,995,000.00	9,365,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,873,437.60	-3,618,896.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,775,000.00	419,884,605.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-96,874.95	-20,861,874.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,583,100.00	136,585,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-38,319,639.93	-51,748,811.97
39300	Биет бус хөрөнгө	1,018,749.98	703,124.92
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-231,250.02	-546,875.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	415,511,155.82	915,217,554.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	29,366,771.29	43,483,691.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29,366,771.29	43,483,691.10
41300	Өглөг	29,366,771.29	43,483,691.10
41360	Бусад өглөг	20,419,273.40	43,483,691.10
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	372,000.00	1,000,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	14,852,173.40	25,780,000.00
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	5,195,100.00	16,703,691.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	386,144,384.53	871,733,863.12
51	Засгийн газрын хувь оролцоо	386,144,384.53	871,733,863.12
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	20,000.00	20,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	519,581,465.00	519,581,465.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-133,457,080.47	352,132,398.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-70,676,882.25	-133,457,080.47
51220	Тайлант үеийн үр дүн	-62,780,198.22	485,589,478.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	415,511,155.82	915,217,554.22

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,562,689.36	604,530,713.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,562,689.36	604,530,713.66
120	Нийтлэг татварын бус орлого	15,562,689.36	604,530,713.66
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	617,353,431.00	1,313,486,972.48
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	601,790,741.64	708,956,258.82
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	78,342,887.58	118,941,235.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,342,887.58	118,941,235.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,342,887.58	118,941,235.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,342,887.58	118,941,235.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,342,887.58	118,941,235.07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-62,780,198.22	485,589,478.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-62,780,198.22	485,589,478.59

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.00	-70,676,882.25	448,924,582.75
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.00	-133,457,080.47	386,144,384.53
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,601,465.00	-70,676,882.25	448,924,582.75
9	Тайлант үеийн үр дүн	0	-62,780,198.22	-62,780,198.22
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	519,601,465.00	-133,457,080.47	386,144,384.53
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	519,601,465.00	352,132,398.12	871,733,863.12
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,601,465.00	-133,457,080.47	386,144,384.53
19	Тайлант үеийн үр дүн	0	485,589,478.59	485,589,478.59

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	617,353,431.00	1,254,245,932.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	617,353,431.00	1,254,245,932.73
120	Нийтлэг татварын бус орлого	617,353,431.00	1,254,245,932.73
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	617,353,431.00	1,254,245,932.73
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	617,410,057.00	1,254,074,014.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,410,057.00	1,254,074,014.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	617,410,057.00	1,254,074,014.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,868,665.60	406,483,500.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	256,868,665.60	406,483,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,534,558.78	125,680,394.13
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	78,534,558.78	125,680,394.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,132,410.60	12,116,790.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	12,132,410.60	12,116,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	154,444,558.30	697,574,898.88
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	140,848,058.30	441,464,046.70
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	13,596,500.00	256,110,852.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,429,863.72	12,218,431.25
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	114,933,998.72	12,218,431.25
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-56,626.00	171,918.47
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-56,626.00	171,918.47
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	90,506.14	33,880.14
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,880.14	205,798.61

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар 34.4 сая төгрөгийн өглөг барагдуулан ажиллах, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2. Зөвлөмж

1. Авлага, өр төлбөрийн тооцооны данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1 Авлаг, өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад тайлант оны ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдаас авах авлагын төлбөр тооцоог харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 13,700.0 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдад өгөх өр төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

2. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн хурлын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлж жил бүр баталж, биелэлтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллана гэж дүрэмдээ заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулах, аймгийн ИТХ-ын 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангаагүй, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталуулан ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 43,484.0 мянган төгрөгийн өр үүсгэн ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заалтыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	13,700.0					1	13,700.0	-	-	-	-
Өр баагдуулан ажиллах	1	43,484.0					1	43,484				
эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулаагүй	1	0,0					1	0,0				
Дүн	3	57,184.0	0	0.0			3	57,184.0				-

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудита д хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	Нийт	1	1			1			